



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

“Цусны донорын Үндэсний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Төвийн “Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам”, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр, Захиргаа, маркетингийн албаны даргын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цусны донорын Үндэсний өдөр”-ийг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийг 1 дүгээр хавсралт, арга хэмжээний төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврах, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулж олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн авлагагүй, сайн дурын цусны доноруудыг “Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам”-д заасны дагуу урамшуулсугай.

3. Удирдамж, төсвийн дагуу “Цусны донорын Үндэсний өдөр”-ийг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч (Б.Ижилбаатар), Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/ нарт даалгасугай.

4. Энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан зардлыг хөтөлбөр, төслийн зардлаас зарцуулахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга-Ахлах нягтлан бодогч (Х.Одгэрэл)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод аудитор (Т.Алимаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ




Н.ЭРДЭНЭБАЯР

D:\bichig heregl2024 onii alban bichig\tushaal\A tushaal.docx

1308010360

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
118/ дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



**2025 ОНЫ "ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР"-ИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ УДИРДАМЖ**

Зорилго:

ЦССҮТ-өөс санаачлан "Цусны донорын Үндэсний өдөр"-ийн хүрээнд ард иргэдэд авлагагүй, сайн дурын цусны донорын үйлсийг сурталчлах, хүн амын дунд цусаа бэлэглэхийн ач холбогдлын талаар мэдээлэл түгээх, олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн байнгын донорыг алдаршуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Зорилт:

1. Цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлах, ард иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэхэд нөлөөлөх, цусаа өгөхийн ач тусыг таниулах нөлөөллийн ажлыг хийнэ.
2. Цусны донорын эгнээг өргөжүүлж, олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн байнгын доноруудыг урамшуулж, донор хадгалалтыг сайжруулна.
3. Байгууллага хамт олноороо авлагагүй сайн дурын цусны донорын эгнээнд нэгдэж олон удаа цусны донорын арга хэмжээ зохион байгуулсан, донорын үйлсийг дэмждэг байгууллага хамт алдаршуулж, оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Цусны донорын Үндэсний өдрийн арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цусны донорын үйлсийг сурталчлах, зөв зэрэг мэдээлэл түгээх;
- 2024 онд хамгийн олон удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн цусны доноруудыг алдаршуулж, урамшуулах;
- Тогтмол хугацаанд цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгч болзол хангасан доноруудад "Хүндэт донор", "Алт, Мөнгө, Хүрэл" донор цол тэмдэг олгох, өргөмжлөх;
- Цусаа өгсөн доноруудад цусны бүлгийн тэмдэг олгож бахархал төрүүлэх;

Хугацаа:

2025 оны 01 дүгээр сарын 03 өдөр.

Гарах үр дүн:

- Донорын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
- Хүн амын дунд авлагагүй, сайн дурын цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирч цусны донорын тоо, тогтмол хугацаанд цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгдөг байнгын донорын тоо, эзлэх хувь нэмэгдэнэ.
- Эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлж, нутагшуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Жил бүр хурдацтай өсөн нэмэгдэж буй цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, эмнэлгийн захиалгыг бүрэн хангах, байнгын нөөц бүрдүүлэх бэлэн байдлыг хангахад зэрэг нөлөө үзүүлнэ.
- Цусны донорууд, цусны донорын үйлсийг талархан дэмждэг байгууллага хамт олны нэр хүнд өсөж, тэдний сайн үйл нийгэмд танигдана.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
А/21 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

2025 ОНЫ "ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР"
ТЭМДЭГЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Уриа: Амьдрал бэлэглэсэн 20 жил, донор танд баярлалаа.

№	Шагналын нэр	Зардлын утга	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Зарцуулагдах төсөв
1.Үндэсний өдрийн арга хэмжээний зардал					
а.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах					
1.	Жилийн хамгийн олон өгөлттэй донор	Өргөмжлөл	2	20 000	40 000
		Гарын бэлэг	2		Гарын бэлэг
2.	Мөнгөн донор өргөмжлөл	Гарын бэлэг	2		Гарын бэлэг
3.	Хүрэл донор өргөмжлөл	Гарын бэлэг	2		Гарын бэлэг
4.	Хүндэт донор цол тэмдэг	Гарын бэлэг	40		Гарын бэлэг
					Гарын бэлэг
	Дүн				40000
б.Арга хэмжээний нээлт, хүлээн авалтын цайны зардал					
4.	Угтах үйлчилгээ цай, ус, бэлэн бүтээгдэхүүн				200 000
	Дүн				200 000
	НИЙТ ДҮН				240 000

-----oOo-----